**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ДАДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН**
**ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2027 оны 03 сарын 27 өдөр Дугаар 06 Баян-Овоо

Эх хэлний салбар зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг , Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 155 дугаар зарлиг, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоол, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоол, "Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажиллах журам"-ын 1.3, 2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Эх хэлний салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---|---|
| Дарга | Засаг дарга |
| Нарийн бичгийн дарга | Нийгмийн бодлогын мэргэжилтэн |
| Гишүүд: | Засаг даргын Тамгын газрын дарга |
| | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга |
| | Ерөнхий боловсролын сургуулийн захирал |
| | Соёлын төвийн дарга |
| | Цэцэрлэгийн эрхлэгч |
| | Эрүүл мэндийн төвийн дарга |
| | Засаг даргын тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч |
| | Эх хэлний багш |
| | Эх хэлний багш |

2. Монгол хэлний тухай хууль, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Аймаг сумын хэлний бодлогын салбар зөвлөлийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг сумын Эх хэлний салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА Б.БАЯСГАЛАН

2325110006